



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 9/36

Бат-Өлзий сум

Тамхи худалдах тусгай зөвшөөрөл  
сунгах тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 16 дугаар зүйлийн 16.3.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Ц.Ганболд эзэнтэй “Зэндмэнэ”, Д.Жавзмаа эзэнтэй “Батбуянт” хүнсний дэлгүүрүүдийн тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2 жилийн хугацаатай сунгасугай.
2. Тамхи худалдаалах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж 100000 (Нэг зуун мянган) төгрөгийг сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг Татварын улсын байцаагч (Н.Батсайхан)-д даалгасугай.
3. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгогдсон дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, (Д.Энх-Амгалан Цагдаагийн ахмад), татварын улсын байцаагч (Н.Батсайхан), Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтны албан тушаалыг түр орлон гүйцэтгэгч (М.Мягмаржав) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН